



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗАР**

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ  
ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

**2024 ОН**

## ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 7 дугаар сарын 4-ны өдөр

Сайншанд сум

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрт тусгагдсан зорилт, арга хэмжээний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлага болон хэрэглэгчдийг шаардлагатай мэдээллээр хангах, цаашид соёлын салбарын үйл ажиллагааг орон нутагт үр нөлөөтэй зохион байгуулахын тулд төлөвлөлт, гүйцэтгэлийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор үнэлгээний ажлыг зохион байгуулав.

### Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.3 дахь заалтыг үндэслэн хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

### Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн тайланд бодлогын асуудал хариуцсан мэргэжилтнүүдээс тодруулга авах, бодит гүйцэтгэлийг нягтлан шалгах зэрэг аргуудыг хэрэглэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийлээ.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 1 хууль, 2 зарлиг, Засгийн газрын 4 тогтоол, 4 хурлын тэмдэглэл, 1 албан даалгаврын нийт 41 арга хэмжээний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, зорилт арга хэмжээ бүрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлээ.

№	Зорилт арга хэмжээний нэр	Биелэлт тооцох арга хэмжээн ий тоо	Биелэлтийн хувь					Дундаж хувь
			100%	70%	30%	0%	ХБ	=
1	2022.05.01. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай /2021-12-17 / МУ-ын хууль	25	18	2			5	97%
2	2022_43. Засгийн газарт чиглэл өгөх тухай /2022-04-05/ Ерөнхийлөгчийн зарлиг	1	1					100%
3	2022_159. Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай /2022-07-11/ Ерөнхийлөгчийн зарлиг	2	2					100%
4	2022_7. Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2022-01-05/ ЗГ-ын тогтоол	1	1					100%
5	2022_139.Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай /2022-04-06/ ЗГ-	2	1	1				85%

	ын тогтоол						
6	2022_203. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2022-05-25 / ЗГ-ын тогтоол	1	1				100%
7	2022_204. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2022-05-25/ ЗГ-ын тогтоол	1	1				100%
8	2022_488. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2022-12-28/ ЗГ-ын тогтоол	1	1				100%
9	2024_59. Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай / 2024-02-14 / ЗГ-ын тогтоол	1	1				100%
10	2024_82. Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай / 2024-02-28 / ЗГ-ын тогтоол	1	1				100%
11	2022_11. 2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл / 2022-02-16 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	1	1				100%
12	2022_28. 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл / 2022-05-11 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	1	1				100%
13	2023_11. 2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл / 2023-03-07 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	1		1			70%
14	2023_25. 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдөр 25 дугаар тэмдэглэл / 2023-06-14 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	1		1			70%
15	2022_6. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг сурталчлан таниулах тухай / 2022-07-05 / ЗГ-ын албан даалгавар	1		1			70%
<b>Нийт</b>		41	30	6		5	95%

#### Дөрөв. Дүгнэлт

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд тусгагдсан 1 хууль, Ерөнхийлөгчийн зарлиг 2, 7 тогтоол, 4 хуралдааны тэмдэглэл, 1 албан даалгавар буюу нийт 41 заалтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 30 заалт 100 хувийн биелэлттэй, 6 заалт 70 хувийн биелэлттэй, 5 заалт хамааралгүй буюу хэрэгжих боломжгүй заалт буюу Хууль тогтоомж тогтоол шийдвэрийн биелэлтийн дундаж 95 хувь байлаа.

Тав. Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ, зөвлөмж

Хууль тогтоомжийн тайлан нь “Бүрэн хэрэгжсэн” гэж үнэлэгдсэн боловч дараах арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах зөвлөмжийг

~~Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн~~ хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Хэрэгжилтийг тайлагнахдаа МУЗГ-н 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын А/675 дугаар захирамжаар тус тус батлагдсан журмын дагуу заасан хугацаанд, үр дүнд суурилсан тайланг бодит тоон мэдээлэлд тулгуурлан бичих
- ✓ Зөвхөн байгууллагын хэмжээнд бус салбарын хэмжээнд хийгдсэн ажлуудыг нэгтгэж тайлагнах
- ✓ Зорилт, арга хэмжээг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаж, хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, ахиц үр дүнг заавал тоон мэдээлэлтэй бүрэн тайлагнах, бодитой үнэлэгдэхүйц тайлагнах шаардлагатай.

Мөн "Хэрэгжих шатанд" буй дараах зарлиг, албан даалгавруудын хэрэгжилтийг эрчимжүүлж, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах;
- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийг ард иргэд, олон нийтэд сурталчлан таниулах;
- ""Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын зорилго, зорилт, үйл ажиллагаа, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар харъяа байгууллагын албан хаагчдад сургалт зохион байгуулах; 1.2."Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого", "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хэрэгжилтийн явцын талаар иргэд, олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг салбарынхаа хэмжээнд зохион байгуулах ажлуудыг эрчимжүүлж үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

ХЯНАСАН:

СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГА

У.ГАНБААТАР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, СТАТИСТИК

МЭДЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

А.НАРАНЖАРГАЛ